



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/108

Хажуу шинэ ус

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр “Улаан толгой”-т байршилтай Баттөмөрийн Оюунбаатар (ЗВ82111313)-ийн өвөлжөө, хаваржааны зориулалттай 5000 м.кв (0.5 га) газрыг Аюушийн Ууганбаяр (ЗЮ79082716)-д зориулалтын дагуу шилжүүлэн 7 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Б. Хорол)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн А/126 тоот захирамжийн хавсралтын 11 дэх хэсэг мөн газар эзэмших эрхийн 000505890 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН

482201108